


БАТЛАВ.
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА Д.УРАНЗАЯА



2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭМИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ E-MONGOLIA ТӨРИЙН ЦАХИМ
ҮЙЛЧИЛГЭЭНД НЭГТГЭЖ БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН БҮРТГҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл: Иргэд, бизнес эрхлэгчдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэх, төрийн үйлчилгээг цахимжуулах хүрээнд МУЗГ-аас E-MONGOLIA төслийг хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас 2018 онд “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолыг баталсан. Уг тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”, “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг тус тус гаргасан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 149 дүгээр тогтоолыг баталсан.

Одоогийн байдлаар E-Mongolia программаар дамжуулан Төрийн 1005 гаруй үйлчилгээг авч байна.

ЭЭХХЗГ-аас Бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой дараах мэдээллийг ЭМЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу E-Mongolia программд оруулах ажлыг хийж байна.

Үүнд:

- Эмийн хэрэглэх заавар болон бүртгэлтэй загварын зураг, бүртгэлтэй эмийн мэдээлэл
- Эм, оношлуур, Биологийн идэвхт бүтээгдэхүүний шинэ бүртгэл, хугацаа сунгалт, өөрчлөлтийн материалыг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.

Хоёр. Зорилго: Бүртгүүлэгч байгууллагууд E-mongolia төрийн цахим үйлчилгээгээр бүртгэлийн материалыг илгээх талаар мэдлэг олгох.

Гурав. Хамрах хүрээ: Эм, БИБ, оношлуур бүртгүүлэгч байгууллагууд

Дөрөв. Зохион байгуулагч: Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтэс, И-Монголиа академи

Тав. Хугацаа: Цахимаар 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 09:00-10:15 цагийн хооронд

Зургаа. Хүрэх үр дүн: Эм, БИБ, оношлуур бүртгүүлэгч байгууллагууд E-Mongolia төрийн цахим үйлчилгээгээр бүртгэлийн материалыг илгээх талаарх мэдлэгтэй болсон байна.

БАТЛАВ.
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА Д.УРАНЗАЯА

ЭМИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ E-MONGOLIA ТӨРИЙН ЦАХИМ
ҮЙЛЧИЛГЭЭНД НЭГТГЭЖ БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН БҮРТГҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

1. Сургалт 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 09:00-10:15 цагийн хооронд цахимаар болно. ZOOM ID нь сургалт эхлэх цагаас 10 минутын өмнө нээгдэнэ.
2. Meeting ID: 957 1032 6214
3. Passcode: 415771

Д/Д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	Уулзалтын нээлт	09:00-09:10	Д.Уранзаяа, ЭЭХХЗГ-ын дэд дарга
2.	Е-Mongolia төрийн цахим үйлчилгээний порталд эм, БИБ, оношлуурын бүртгэлийн материал хэрхэн илгээх	09:10-10:00	С.Цэвээнсүрэн И-Монголиа академи УТҮГ нэвтрүүлэлт, ашиглалтын ахлах мэргэжилтэн
3.	Асуулт, хариулт	10:00-10:10	С.Цэвээнсүрэн И-Монголиа академи УТҮГ нэвтрүүлэлт, ашиглалтын ахлах мэргэжилтэн
4.	Уулзалтын хаалт	10:10-10:15	Т.Мөнхтуул, ЭЭХХЗГ-ын ЭБХ-ийн дарга